



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

ӨЛЗИЙТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Ч.БУЯНЖАРГАЛ ТАНАА

2016.11.24

№

01/188

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9, аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Өлзийт сумын Цэцэрлэгийн 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар нийт 109,864,915.50 /Нэг зуун есөн сая найман зуун жаран дөрвөн мянга есөн зуун арван таван төгрөг тавин мөнгө/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ.

1. Дээвэр, халаалтын засварын 94,454,212.00 төгрөгийн зардлыг барилгын өөрийн өртөгт нэмж капиталжуулаагүй /тусд нь бүртгэсэн/ байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.34-т /Үндсэн хөрөнгийн засварын зардал нь үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг уртасгах гэх мэт уг хөрөнгөөс хүртэх эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлж байвал уг зардлыг капиталжуулан үндсэн хөрөнгийн анхны өртгийг нэмэгдүүлнэ. Бусад тохиолдолд тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө/ заасныг зөрчсөн байна.

2. Хүнсний материалын анхан шатны хуурамч баримт бүрдүүлэн зарцуулалт хийж, цахилгааны төлбөрт 413,000.00 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, Төсвийн тухай хуулийн 16.5.5-д /Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ заасныг тус тус зөрчсөн.

3. Аудит хийх явцад 14,997,704.45 төгрөгийн хүнсний материалыг цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг нормоор бодоогүй, хяналтгүй зарцуулж зардалд тайлагнасан байна.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2014 оны 113 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад /1-18 насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг/, Төсвийн тухай хуулийн 41.2.3-т /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т

/Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй / заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Жилийн эцсийн санхүүгийн тайланд их засварыг бүртгэсэн бичилтийг залруулах.
2. Анхан шатны баримтыг үнэн зөв бүрдүүлж төсвийг зориулалтын дагуу зарцуулах, зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах хуурамч баримтаар гүйлгээ хийж бүртгэлд тусгахгүй байх, төсвийг зориулалтын дагуу зарцуулах
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 20-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Өлзийт сумын Цэцэрлэгийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгч /Ч.Буянжаргал/, нягтлан бодогч /Г.Мөнхбаясгалан/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН!

ШИНЖЭЭЧ




Ж.УГТАХБАЯР

ЭРХЛЭГЧ

НЯГТЛАН БОДОГЧ

ЗӨВШӨӨРСӨН:



Ч.БУЯНЖАРГАЛ

Г.МӨНХБАЯСГАЛАН

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.